

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ:

СУДЛААЧ:

УЛААНБААТАР ХОТ

## **АГУУЛГА**

### **УДИРТГАЛ**

#### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ**

#### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

#### **ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал  
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

#### **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-т Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч туслах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээрт үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгажээ.

Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргасан бодлогын хүрээнд боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн<sup>1</sup> зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>2</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилготой.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

1 Ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төсөл

2 [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Сүүлийн нэвтрэлт 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

## **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ**

Энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>3</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

### **Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

#### **➤ Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь хуулийн төслийн шинэчлэлээр тухайн зохицуулалтын хүрээнд тулгамдсан бэрхшээл, зөрчил, хийдлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь анх дэвшүүлсэн зорилго буюу хуулийн төслийн үзэл баримтлалд<sup>4</sup> тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн түүнийг шийдвэрлэж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **➤ Практикт хэрэгжих боломж:**

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно.

#### **➤ Ойлгомжтой байдал:**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг тул Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Иймд энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>5</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **➤ Харилцан уялдаа:**

<sup>3</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9-т "...хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

<sup>4</sup> Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Үзэл баримтлал. 2025 он.

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

Хуулийн төслийн эх бичвэр нь Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчил, хийдэлгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг<sup>6</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Энэхүү хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн төслийн ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл, заалтын үр нөлөөг судална.

### **2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал**

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 11 бүлэг 59 зүйлийн хэсэг, заалтууд ямар нэгэн байдлаар хөндөгдсөн байна. Ингэснээр хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, хөрөнгө оруулалтыг бууруулах эрсдэлд хөтөлж байна.

Хууль хэрэгжсэн хугацаанд Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үндсэн зорилго нь геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангах, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийвчлан зохицуулах, бусад хуультай нийцүүлэх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах

зорилготой бөгөөд энэ хүрээнд дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна: **Үүнд:**

- баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулах;
- уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлттэй холбогдох харилцааг зохицуулах;
- хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, тусгай зөвшөөрлийн төлбөр, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг болон тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг тодорхой болгох;
- стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг тодорхой болгох.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ, шаардлагыг дээрх байдлаар тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд энэ талаар хэрхэн тусгасан талаар харьцуулан бичиж, тухайн зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой, хуулийн төсөлд боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж харьцуулна.

Иймд хуулийн төслөөс дээрх зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл, хэсэг, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг нь тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулах	1 дүгээр зүйл 1/ “ДӨРӨВДҮГЭЭР1 БҮЛЭГ Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх
2.	Уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлттэй холбогдох харилцааг зохицуулах	1 дүгээр зүйл 2/ “ЗУРГААДУГААР1 БҮЛЭГ Уурхай, үйлдвэрийн хаалт

3.	Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох харилцааг зохицуулах	2 дугаар зүйл 1/ “18 <sup>1</sup> дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх 2/ “20 <sup>1</sup> дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх
4.	Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тусгах	2 дугаар зүйл 3/ “30 <sup>1</sup> дүгээр зүйл.Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа
5.	Олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг тодорхой болгох;	2 дугаар зүйл 4/ “42 <sup>1</sup> зүйл.Олон нийтийн оролцоо

## **2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал.**

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан эрх зүйн зохицуулалтууд нь бодитой хэрэгжих боломжтой эсэхийг судлах замаар үр нөлөөг үнэлэх бөгөөд Монгол Улсад баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төрөл болон уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг хуульчлаагүй бөгөөд практикт турших боломжгүй байна.

Туршилт явуулахад хамрагдах холбогдох тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байхгүй мөн туршилт явуулахад санхүү, эдийн засгийн хувьд хүндрэлтэйгээс гадна боломжгүй тул олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлнэ.

## **2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал**

Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах бөгөөд “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн хэсэг, зүйл, заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

## **2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал.**

Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах бөгөөд “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн хэсэг, зүйл, заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

## **ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар хүснэгтэд харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл 1/ “ДӨРӨВДҮГЭЭР <sup>1</sup> БҮЛЭГ Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх 2/ “ЗУРГААДУГААР <sup>1</sup> БҮЛЭГ Уурхай, үйлдвэрийн хаалт 2 дугаар зүйл 1/ “18 <sup>1</sup> дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх 2/ “20 <sup>1</sup> дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх 3/ “30 <sup>1</sup> дүгээр зүйл.Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа 4/ “42 <sup>1</sup> зүйл.Олон нийтийн оролцоо	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл  1/ “ДӨРӨВДҮГЭЭР <sup>1</sup> БҮЛЭГ Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх  2/ “ЗУРГААДУГААР <sup>1</sup> БҮЛЭГ Уурхай, үйлдвэрийн хаалт	Бусад улс орнуудад практикт хэрхэн зохицуулж, хуулийг хэрэгжүүлж байгаад дүн шинжилгээ хийх
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хууль болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах

### 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг багц байдлаар харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үндсэн хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон бөгөөд эдгээр зорилтуудыг хангах чиглэлээр хуулийн төсөлд тодорхой зохицуулалт тусгасан эсэхийг шалгаж үзвэл:

➤ ***Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулах***

1.Хуулийн төсөлд баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхлэхээр, мөн тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар 3 удаа сунгаж болохоор тусгаснаас гадна тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт зэргийг нарийвчлан тусгасан нь эрх зүйн зохицуулалт энэ төрлийг тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тодорхой, ойлгомжтой байна. Энэ нь баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулах үндсэн зорилгод бүрэн нийцсэн байна.

Түүнчлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй, мөн ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүсэх үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахаар заасан нь үүсмэл орд ашиглах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгосон дэвшил болжээ.

2.Харин Зөвшөөрлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулахад оршино.” гэж, 1.3 дугаар зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж тус тус зааж, Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтыг хуульчилсан.

Тодруулбал, зөвшөөрлийн харилцаанд үйлчлэх нийтлэг зохицуулалтыг хуульчилсан Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох нийтлэг зохицуулалтыг тусгасан атал хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх харилцааг огт зохицуулаагүй нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хооронд маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүйг анхаарах шаардлагатай.

Мөн хуулийн төсөлд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төрөлд “баяжуулалтын тусгай зөвшөөрөл”-ийг шинээр нэмсэн байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуулийн зохицуулалтайг анхаарах нь зүйтэй байна.

3.Хуулийн төслийн 28<sup>2</sup>.2-т Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээхээр заасан хэдий ч олон олон нийтэд мэдээлэх хэлбэр, түүний давтамжийг тодорхой тусгаагүйн улмаас уг үүргийг хэрэгжүүлэхгүй байх, хэлбэр төдий байдлаар хэрэгжих нөхцөл үүсэхээр байна.

➤ **Уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлттэй холбогдох харилцааг зохицуулах**

Хуулийн төсөлд уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг уурхайн олборлолт болон баяжуулалтын үйл ажиллагааг дахин сэргээхгүй байдлаар хаах **төлөвлөгөөт хаалт**, давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх боломжгүйн улмаас хугацаанаас өмнө дахин сэргээхгүй байдлаар **хаах гэнэтийн хаалт** болон хайгуулаар тогтоогдсон нөөц батлагдаагүй, нэмэлт хайгуул хийх шаардлагатай болсон, технологийн горим алдагдсан, технологийн шинэчлэл хийх нөхцөл, шаардлагын улмаас дахин сэргээх боломжтой байдлаар **хаах түр хаалт** гэсэн 3 төрөлтэй байхаар тусгаж, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг ашиглалт, баяжуулалтын үе шат тус бүрээр боловсруулахаар заасан нь уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлттэй холбогдох харилцааг зохицуулах үндсэн зорилгод бүрэн нийцсэн байна.

➤ **Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох харилцааг зохицуулах**

Хуулийн төсөлд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам зэргийг нарийвчлан тусгасан нь тухайн харилцааг зохицуулах үндсэн зорилгод нийцсэн хэдий ч дараах хэд хэдэн асуудлыг анхаарах шаардлагатай байна.

1.Хуулийн төслийн 20<sup>1</sup>.1.3-д “өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт

олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан, мөн түрүүлж ирүүлсэн өргөдөлд тусгагдсан талбайтай бүхэлдээ давхацсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэх;” гэж заасан зохицуулалтын агуулгаас үзэхэд түрүүлж ирүүлсэн өргөдөл гаргагчид давуу байдал олгох, энэ нь улмаар өргөдөл бүртгэх чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдэд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй байна.

2.Хуулийн төслийн 18<sup>1</sup>.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг төрийн захиргааны байгууллагын баталсан маягтаар гаргах бөгөөд түүнд дараах бичиг баримтыг хавсаргана” гэж заасан хэдий ч ямар маягт болох нь тодорхойгүй байна. Тодруулбал Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.27-д “сонгон шалгаруулалтын урилгын маягт, загварыг батлах” эрх төрийн захиргааны байгууллагад байгаа боловч хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт батлах эрхийг хуулиар олгоогүй бөгөөд мөн хуулийн төсөлд уг зохицуулалтыг тусгаагүй байна.

3.Хуулийн төслийн 20<sup>1</sup>.3-т “Энэ хуулийн 201.2.1-т заасан хугацаанд тухайн талбайд санал ирүүлсэн этгээдүүдийн дунд дуудлага худалдааг зарлан явуулах ба дуудлага худалдааг энэ хуулийн 10.1.23-т заасан журмаар зохицуулна” гэж, мөн төслийн 10.1.23-т “хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг батлах;” эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгохоор тусгасан байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу тус хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлд хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад тавих шаардлагыг тогтоосон болохыг анхаарах нь зүйтэй.

➤ **Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тусгах**

Хуулийн төсөлд стратегийн чухал ашигт малтмал гэх шинэ төрлийн харилцааг тусгаж, олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг ойлгохоор тусгаж, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалын талаар судлан, стратегийн чухал ашигт малтмалд хамруулах саналыг Засгийн газарт хүргүүлж, тухайн саналыг үндэслэн стратегийн чухал ашигт малтмалын жагсаалтыг Засгийн газар батлахаар заасан нь стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тусгах үндсэн зорилтод нийцсэн байна.

Харин төслийн 301.3-т “байгалийн нөөц газар, дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авсан газар болон улсын хилийн зурвас газарт улсын төсвийн хөрөнгөөр стратегийн чухал ашигт малтмалын суурь судалгаа хийхийг Улсын их хурал, Засгийн газар бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх” гэж заасан нь ойлгомжгүй байх бөгөөд уг зохицуулалтыг сайжруулан боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

➤ **Олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг тодорхой болгох**

Хуулийн төсөлд геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаан дах олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг зүйл хэлбэрээр боловсруулсан дэвшилттэй хэдий ч зарим зохицуулалтыг анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, хуулийн төслийн 42<sup>1.2</sup>-т “Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно” гээд 42<sup>1.2</sup>-д “эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх” гэж тусгасан байна. Энэ нь Иргэн, төрийн бус байгууллагад үүрэг болгосон зохицуулалт байх бөгөөд, тэдгээрийн эрхийг хөндсөн агуулгатай зохицуулалт байна. Мөн тус хэсэгт тусгасан “явцуу ашиг сонирхол” гэдгийг хэрхэн ойлгох, хэн тогтоох зэрэг нь тодорхойгүйн улмаас иргэдийн эрх, хөндөгдөх эрсдэл үүсэхээр сэргийлэх нь зүйтэй.

### **3.2.”Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалттай холбоотой тодорхой тохиолдлыг бий болгож, тухайн хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээг холбогдох байгууллага, этгээдийг оролцуулан туршилт явуулахаар Монгол Улсын *Засгийн газрын 2016 оны*

*59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн үр нөлөөг тооцох аргачлалын 4.6-д заасан байна.*

Гэвч хуулийн төсөлд тусгасан баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төрөл болон уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа нь одоогын хууль тогтоомжид тусгагдаагүй тул туршилт явуулах боломжгүй байна.

Мөн журмын 4.6.2-т туршилт явуулахад их хэмжээний зардал, хүн хүч шаардаж байгаа, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, холбогдох этгээд туршилтын ажиллагаанд оролцохыг зөвшөөрөөгүй тохиолдолд туршилтын ажиллагаа явуулахаас зайлсхийж, тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, хуулийн этгээдээс санал авах замаар энэ шалгах хэрэгслийг хэрэглэж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ гэж заасны дагуу бусад төрийн байгууллагууд болох Яам, агентлаг, чөлөөт бүсийн захиргаа болон хөрөнгө оруулах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүдээс санал авах шаардлагатай.

Харин баяжуулалтын үйл ажиллагаа болон уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудад практикт туршигдсан, хэрэгжих боломжтой болох нь дараах судалгаануудаар тогтоогдсон гэж үзэхээр байна. Үүнд:

#### **Баяжуулалтын үйл ажиллагаа**

Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар бөгөөд олборлолтоос гадна баяжуулалт, боловсруулах үйл ажиллагаа нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч Монгол Улсад баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг нарийвчлан тусгасан, өөрийн онцлог бүхий хууль, журмын тогтолцоо хангалттай боловсронгуй биш

хэвээр байна. Үүнтэй холбогдуулан энэхүү судалгаагаар Монгол Улсын баяжуулалтын эрх зүйн орчныг Өмнөд Африк, Индонез, Чили, Канад (Британи Колумби муж)-ын жишээтэй харьцуулан судалж, эрх зүйн бодлого, тусгай зөвшөөрлийн тогтолцоо, байгаль орчны хяналт, дотоод боловсруулалтын шаардлага зэрэгт тулгуурласан харьцуулалт хийв.

➤ *Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын тойм*

Монгол Улсад ашигт малтмалын баяжуулалт, боловсруулах үйл ажиллагаа нь Ашигт малтмалын тухай хуульд тулгуурладаг. Тус хуульд баяжуулах үйлдвэрийг байгуулах, ашигт малтмалыг боловсруулах, экспортлохтой холбоотой харилцааг гол төлөв “ашиглалтын тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд зохицуулж ирсэн. Өөрөөр хэлбэл, баяжуулалт нь олборлолтын үйл ажиллагааны нэг хэсэгт тооцож, бие даасан тусгай зөвшөөрөл шаардлагагүй гэж үздэг. Гэвч сүүлийн жилүүдэд ашигт малтмалыг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг бий болгох, экспортын бүтээгдэхүүний төрөлжилтийг дэмжих бодлого идэвхтэй яригдаж байна. Үүнд “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”, “Аж үйлдвэрийн парк байгуулах тухай хуулийн төсөл”, мөн “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого — Алсын хараа 2050”-д туссан “баяжуулах үйлдвэрлэлийн өргөтгөлийн стратеги” гол үндэс болдог.

➤ *Өмнөд Африк (South Africa)*

Өмнөд Африкийн Mineral and Petroleum Resources Development Act (MPRDA) нь баяжуулалтын асуудлыг тусгайлан авч үзсэн цөөн улсын нэг юм. Хуулийн 26-р зүйлд “сайд нь дотоодод ашигт малтмалын боловсруулалт, нэмүү өртөг шингээх үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх бүрэн эрхтэй” гэж заасан байдаг. Энэ нь зөвхөн олборлолт төдийгүй баяжуулалтын үе шатанд төрийн идэвхтэй оролцоог баталгаажуулдаг.

Баяжуулах үйлдвэрүүдийг байгуулахад олборлолтын тусгай зөвшөөрлөөс гадна байгаль орчны зөвшөөрөл, эрчим хүч ашиглах зөвшөөрөл, аюулгүй ажиллагааны аудит зэрэг нарийн шат дамжлага шаарддаг. Үүнээс гадна үнэт метал, очир алмаз зэрэг стратегийн бүтээгдэхүүнд тусгай лиценз олгодог Precious Metals Act, Diamonds Act зэрэг салбар хуулиуд байдаг. Энэ зохицуулалт нь баяжуулалтын үйл ажиллагааг хянах, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж, “хар эдийн засгийг” хязгаарлах, баялгийн шударга хуваарилалтыг дэмжихэд үр дүнтэй гэж судлаачид үздэг.

➤ *Индонез*

Индонез улс 2009 онд баталсан Уул уурхай ба нүүрсний тухай хууль (Law No. 4/2009) болон түүнд 2020, 2023, 2025 онд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр баяжуулалтын бодлогоо үндсээр нь шинэчилсэн. Энэхүү хуулиар олборлогч бүх аж ахуйн нэгжид түүхий хүдэр экспортлохыг хязгаарлаж, дотооддоо боловсруулах (smelting/beneficiation) үйл ажиллагаа эрхлэхийг заавал шаарддаг болсон. Баяжуулалтын үйлдвэр байгуулах, өргөтгөхөд зориулсан тусгай зөвшөөрлийг Эрчим хүч ба ашигт малтмалын нөөцийн яам (ESDM) олгодог бөгөөд тухайн үйлдвэрийн “ажлын төлөвлөгөө ба төсөв (RKAB)” жил бүр шинэчлэгдэж батлагдах ёстой. 2025 оны шинэ нэмэлт хуулиар тус

зөвшөөрлийн хүчинтэй хугацааг 1 жил болгож, жил бүр нөхөн баталгаажуулах механизмыг нэвтрүүлсэн.

Энэ бодлого нь дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, 2024 оны байдлаар Индонезид 40 гаруй зэс, никель, бокситын баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа ч гадаад хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн гэж олон улсын судлаачид үздэг.

➤ *Чили*

Чили улс нь зэсийн баяжмал экспортын дэлхийд тэргүүлэгч боловч сүүлийн жилүүдэд боловсруулах үйлдвэр байгуулах эрх зүйн орчноо илүү уян хатан болгож эхэлжээ. Чилийн Байгаль орчны үнэлгээний систем (SEIA) нь уул уурхайн болон боловсруулах төслүүдийг хянан баталгаажуулдаг бөгөөд баяжуулалтын үйлдвэр SEIA-гаар байгаль орчны гэрчилгээ авсны дараа бусад тусгай зөвшөөрлийг авдаг. 2025 онд батлагдсан шинэ “Permitting Acceleration Law” нь уул уурхай, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн зөвшөөрөл олгох хугацааг 30–70 хувиар хурдасгах зорилготой бөгөөд нэг цонхны зарчим бүхий цахим системийг нэвтрүүлж байна. Энэ нь зөвшөөрлийн шат дамжлагыг хялбаршуулж, дотоод боловсруулалтын төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын шинэ үеийг нээж байна.

➤ *Канад – Британи Колумби муж*

Канадын уул уурхайн тогтолцоо нь холбооны бус, мужийн бүрэн эрхийн асуудал бөгөөд Британи Колумби (BC) муж нь баяжуулалтын үйл ажиллагаанд хамгийн нарийн зөвшөөрлийн тогтолцоотой. Баяжуулалтын төслүүд Mines Act, Environmental Assessment Act, Environmental Management Act гэсэн гурван үндсэн хуулийн дагуу хэрэгждэг. “Mines Act permit” нь уурхай болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг нэгтгэн хамруулдаг цогц зөвшөөрөл бөгөөд нөхөн сэргээлт, аюулгүй ажиллагаа, ус хангамж, хаягдал боловсруулах төлөвлөгөөг багтаадаг.

2025 онд тус мужийн “Highland Valley Copper” төслийн өргөтгөлийн хүрээнд Environmental Assessment certificate олгосон нь баяжуулалтын шинэ үе шатны хяналт, зөвшөөрлийн жишиг болж байна. Мөн тус мужийн MineSpace нэртэй цахим платформоор зөвшөөрлийн явцыг ил тод хянах, иргэдийн оролцоог хангах системийг хэрэгжүүлж байна.

### **Уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа**

Уул уурхайн үйл ажиллагаа нь байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөгжлийн чухал эх үүсвэр болдог хэдий ч, нөгөө талаас хүрээлэн буй орчин, экосистем, орон нутгийн амьдралд урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэл дагуулдаг. Тиймээс олборлолтын төгсгөл буюу уурхайн хаалтын үе шат нь зөвхөн техникийн бус, харин нийгэм, эдийн засаг, байгаль орчны цогц зохицуулалт шаардсан үйл явц юм. “Уурхайн хаалт” гэдэг ойлголт нь олборлолт дууссаны дараа уурхайн талбайг байгаль орчны болон нийгмийн хувьд тогтвортой, аюулгүй байдалд шилжүүлэх, мөн тухайн газар нутгийг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг хамардаг. Монгол

Улсад уурхайн хаалтын асуудал хуулиар тодорхой хэмжээнд тусгагдсан байдаг боловч, олон улсын түвшний зохицуулалттай харьцуулахад харьцангуй ерөнхий, хэрэгжилтийн механизмаар сул байна.

➤ *Монгол Улсын уурхайн хаалтын эрх зүйн орчин*

Монгол Улсад уурхайн хаалтын тухай заалтыг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд хэсэгчлэн тусгасан байдаг. Гэвч эдгээр хуулиудад уурхайн хаалтын нарийн тодорхойлолт, шат дараалсан журам, хариуцлагын механизм, санхүүгийн баталгааны системийг бүрэн тусгаагүй байгаа нь эрх зүйн цоорхой үүсгэж байна. Одоогийн эрх зүйн зохицуулалтаар ашигт малтмал ашиглагч нь уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулж, байгаль орчныг нөхөн сэргээх үүрэгтэй гэж заасан боловч, энэ төлөвлөгөөг хэн, ямар шалгуураар батлах, хэрэгжилтийг хэрхэн хянах талаар тодорхой журам үгүй байна. Хаалтын төлөвлөгөөг ихэвчлэн зөвхөн “түр нөхөн сэргээлт” буюу олборлолтын үеийн хязгаарлагдмал арга хэмжээгээр ойлгож, уурхайн бүрэн хаалт болон тухайн газрын дараах ашиглалтын менежментийг тусгадаггүй.

➤ *Канад*

Уул уурхайн хаалтын эрх зүйн хамгийн боловсронгуй тогтолцоог бий болгосон орны нэг юм. Холбооны түвшинд “Canadian Environmental Assessment Act” буюу Байгаль орчны үнэлгээний тухай хууль, муж бүрт үйлчилдэг “Mines Act” буюу Уурхайн тухай хуулиар уурхайн хаалтын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг. Жишээлбэл, Британи Колумби мужид уурхай нээхээс өмнө заавал “Mine Closure Plan” буюу уурхайн хаалтын төлөвлөгөөг батлуулах шаардлагатай байдаг. Энэ төлөвлөгөөнд газрын дараах ашиглалт, хаягдлын далангийн менежмент, усны чанарын хяналт, орон нутгийн шилжилт ба нийгмийн дэмжлэгийн арга хэмжээ зэргийг нарийвчлан тусгадаг. Канадын онцлог нь санхүүгийн баталгааг “Reclamation Bond” хэлбэрээр заавал байршуулдаг оршино. Энэ баталгаа нь компаниас банк, даатгал, эсвэл төрийн баталгаатай сангийн хэлбэрээр гаргагддаг бөгөөд нөхөн сэргээлт бүрэн дуусах хүртэл төрийн хяналт дор хадгалагдана. Уурхайн хаалтын дараах хяналтын хугацаа дунджаар 5–10 жил үргэлжилдэг бөгөөд энэ хугацаанд ус, хөрсний чанар, ургамлын нөхөн сэргэлтийг хянах үүрэгтэй. 2025 оноос Канадын Байгаль орчны яам уурхайн хаалтын цахим тайлагналын системийг бүрэн нэвтрүүлсэн нь ил тод байдлыг эрс нэмэгдүүлсэн.

➤ *Австрали*

Уул уурхайн салбараа хатуу хяналтын тогтолцоонд оруулсан бөгөөд хаалтын үйл ажиллагааг “Mining Act 1978 (WA)” болон “Environmental Protection Act 1986”- аар зохицуулдаг. 2011 онд батлагдсан “Western Australia’s Mine Closure Guidelines” нь уурхайн хаалтын төлөвлөгөөг олборлолт эхлэхээс өмнө батлуулахыг заавал болгосон бөгөөд төлөвлөгөөг гурван жил тутам шинэчлэх үүрэгтэй гэж заасан. Австрали улс уурхайн хаалтын санхүүгийн баталгааг “Mining Rehabilitation Fund (MRF)” нэртэй төвлөрсөн санд байршуулдаг. Компани бүр олборлолтын хэмжээ, эрсдэлийн түвшинд үндэслэн тодорхой хувь нэмэр төлж, уг санг төрийн байгууллага удирдан, орхигдсон уурхайг нөхөн сэргээхэд ашигладаг. Энэ системийн давуу тал нь компани дампуурсан ч

хаалтын ажлыг тасалдуулахгүйгээр үргэлжлүүлэх боломжийг хангадаг оршино.

➤ *Чили улс*

Уул уурхайн хаалтын тусгай хуулийг 2012 онд баталсан бөгөөд “Law No. 20.551 on Mine Closure” нэртэй энэхүү хууль нь Латин Америк дахь хамгийн бүрэн бүтэн загвар гэж тооцогддог. Тус хуулиар уурхайн хаалтын төлөвлөгөөг олборлолтын лиценз авахын өмнө батлуулах ёстой бөгөөд хаалтын санхүүгийн баталгааг “closure guarantee” хэлбэрээр банктай гэрээ байгуулж төрийн хяналтад байршуулах журамтай. Чилийн “National Service of Geology and Mining” буюу SERNAGEOMIN байгууллага хаалтын үйл ажиллагааг хянан шалгаж, тайлагналыг цахим хэлбэрээр хүлээн авдаг. 2025 оноос Чили улс уурхайн хаалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Portal Cierre” нэртэй цахим системийг нэвтрүүлж, олон нийтийн оролцоог хангаж эхэлсэн. Энэ тогтолцоо нь уул уурхайн компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ орон нутгийн иргэдийн итгэлийг дээшлүүлж байна.

➤ *Финланд*

Байгаль орчны өндөр стандарттай орнуудын нэг бөгөөд уурхайн хаалтын асуудлыг “Mining Act (621/2011)” болон “Environmental Protection Act (527/2014)” хуулиудаар нарийвчлан зохицуулдаг. Тус улсын эрх зүйн тогтолцоонд уурхайн хаалтын төлөвлөгөөг олборлолтын зөвшөөрлийн салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд олборлолт эхлэхээс өмнө санхүүгийн баталгааг бүрэн гаргаж байршуулах үүрэгтэй. Хаалтын дараах хяналтын хугацаа 20 жил хүртэл үргэлжилж болох бөгөөд байгаль орчны агентлаг (SYKE) болон орон нутгийн захиргаа хамтран хяналт тавьдаг. Финландын загвар нь “zero pollution principle” буюу “байгальд сөрөг нөлөөг бүрэн арилгах” зарчимд тулгуурладаг бөгөөд энэ нь хариуцлагын өндөр түвшинг илтгэнэ.

Хуулийн төслийн тандан судалгаанд дурдсанчлан олон улсад ашигт малтмалын салбарын хариуцлагыг нэмэгдүүлэх, газар түүний доорх баялгийн тогтвортой, үр ашигтай байдлыг улам нэмэгдүүлэх замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж байх бөгөөд энэ нь тус салбарын нэгдсэн бодлого, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт, хариуцлага, хяналтын тогтолцоо тус бүрийг хуульчлан тогтоож дагаж мөрдөж байгаан илрэл бөгөөд иргэний эрх зүйт төртэй улс орнуудад зайлшгүй байх хууль эрх зүйн хэм хэмжээ болсон нь хуулийн төслийн тандан судалгаагаар тогтоосон байна.

Хуулийн төслөөр баяжуулалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, мөн уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг хуулиар зохицуулж, олон жил практикт хэрэгжүүлсэн дээрх улс орнуудын хууль тогтоомж, практикт тулгуурлан олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.

**3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл нь хууль зүйн техник, боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг<sup>8</sup> хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Хуулийн төслийг боловсруулах ажлыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэсэн байна. Үүнд:

- a) Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл боловсруулах аргачлалын 3.2.1, 3.2.5 болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалснаас гадна хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн;
- b) Хуулийн төслийн тандан судалгаа болон хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан;
- c) Хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл буюу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хэлбэрээр боловсруулжээ.

**Хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх талаарх дүгнэлт:**

Шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. **Үүнд:**

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн, ямар нэгэн байдлаар зөрчил үүсгээгүй.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааг бүрэн тусгасан байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

<sup>8</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10 дахь заалт.

нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Одоогоор хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн заалтыг давхардуулан заасан зүйлгүй.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг бүрэн тусгасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан хэдий ч хуулийн төслийг боловсруулаагүй байна.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

### 3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд заасан стандарт асуултуудад хариулах байдлаар шалгах бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь хамруулахаар тооцлоо. Үүнд:

○ Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Үгүй	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 16/ “47.22.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 20 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.” 17/ “47.23.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.” гэж тус тус заасан нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.” гэж заасан зарчимтай нийцэхгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай давхардаагүй байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3/ “10.4.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн технологийн зураг төсөл боловсруулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны журам батлах,” гэж хуульд нэмэхээр

			тусгасан боловч тус журмыг батлах субъектыг тусгаагүй байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай асуудлыг Зөвлөмжид тусгав.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Тухайн хуулийн зохицуулалт нь төрийн хатуу хяналт дор явуулах нийгмийн харилцаа учраас хуулиар тогтоосон үндсэн чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй юм.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм	Ашигт малтмалын тухай хуулиар АМНАТ-ыг зохицуулдаг практиктай бөгөөд харин төсвийн хувиарлалтын асуудлыг хуулийн төсөлд тусгасан байна. Энэ талаар Зөвлөмж хэсэгт тусгав.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төслийг дагалдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар Үзэл баримтлалд тусгасан боловч тус хуулийн төслийг боловсруулаагүй байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн зохицуулалт байхгүй, хуулийн төслийн зарим заалт өөр хоорондоо давхардал, хийдэл үүсгэсэн байх тул алдааг засварлах, зарим нэмэлт зохицуулалтыг тусгах зэргээр хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шаардлагатай байна.

### **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр

тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн Дүгнэлт хийж, дараах Зөвлөмжийг боловсрууллаа.

### **ДҮГНЭЛТ:**

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Тухайлбал, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх харилцааг огт зохицуулаагүй нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хооронд маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүйг анхаарах шаардлагатай. Мөн хуулийн төсөлд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төрөлд “баяжуулалтын тусгай зөвшөөрөл”-ийг шинээр нэмсэн байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуулийн зохицуулалтайг анхаарах нь зүйтэй байна. Мөн хуулийн төсөлд геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дах олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг зүйл хэлбэрээр боловсруулсан дэвшилттэй хэдий ч зарим зохицуулалтыг анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, хуулийн төслийн 42<sup>1.2</sup>-т “Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно” гээд 42<sup>1.2</sup>-д “эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх” гэж тусгасан байна. Энэ нь Иргэн, төрийн бус байгууллагад үүрэг болгосон зохицуулалт байх бөгөөд, тэдгээрийн эрхийг хөндсөн агуулгатай зохицуулалт байна. Мөн тус хэсэгт тусгасан “явцуу ашиг сонирхол” гэдгийг хэрхэн ойлгох, хэн тогтоох зэрэг нь тодорхойгүйн улмаас иргэдийн эрх, хөндөгдөх эрсдэл үүсэж болзошгүй байна.
- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төслөөр баяжуулалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, мөн уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг хуулиар зохицуулж олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.
- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан, ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.

- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч төсвийн хувиарлалттай холбоотой зохицуулалтыг төслийн 3 дугаар зүйлийн 17/, 18/ дахь хэсэгт тусгасан нь Төсвийн тухай хуулийн зарчимтай нийцэхгүй байна. Мөн хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Хуулийн төсөлд дараах агуулгын чанартай зохицуулалт нэмэх, зүйл, заалтыг тодруулах зорилгоор өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд:

#### **Нэг. Хуулийн төслийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал:**

- Хуулийн төсөлд баяжуулалтын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх харилцааг тодорхой тусгах, мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуулийн зохицуулалтайг анхаарах;
- Хуулийн төслийн 28<sup>2</sup>.2-т Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээхээр заасан хэдий ч олон нийтэд мэдээлэх хэлбэр, түүний давтамжийг тодорхой тусгах;
- Хуулийн төслийн 18<sup>1</sup>.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг төрийн захиргааны байгууллагын баталсан маягтаар гаргах бөгөөд түүнд дараах бичиг баримтыг хавсаргана” гэж заасантай уялдуулан Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт, загварыг батлах” эрхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлд нийцүүлэн нэмж тусгах;
- Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 16/-д “47.22.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 20 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.” гэж, мөн зүйлийн 17/-д “47.23.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.” гэж тус тус заасан нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Төсвийн

харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.” гэж заасан зарчимтай нийцэхгүй тул хасах;

- Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3/-т “10.4.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн технологийн зураг төсөл боловсруулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны журам батлах;” гэж хуульд нэмэхээр тусгасан нь шинэ төрлийн зөвшөөрөл байх тул Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээг авах;
- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 14/-т “9.1.19.Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглах бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.” гэж заасан тул журмыг батлах бүрэн эрхийг Засгийн газарт олгосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах;

#### **Хоёр.Бусад :**

- Хуулийн төслийг үзэл баримтлалд тусгасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг шинээр боловсруулах, Газрын тухай, Зөрчлийн тухай, Зөвшөөрлийн тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Татварын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиуд болон бусад хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэнэ.” гэж, 38 дугаар зүйлийн 38.4-т “Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3, 40.1.4-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.” гэж тус тус заасан шаардлагыг хангах.

## ТАВ.АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хууль тогтоомжийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2016 он
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.08.10-ны өдрийн байдлаарх/
- Хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. 2025 он
- Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан. 2025 он

---oOo---